



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Халхгол нэгдэл ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДОА-2022/09/НА/СТА-ОНА

<p>Цахим хуудас: www.audit.mn Чойбалсан хот 2022 он</p>	<p>Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn Аудитын менежер: И.Сэмжидмаа Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Нармандах Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn Аудитор: Б.Оюунхэрлэн Утас: 7058-4204, Цахим хаяг: oyunkherlenb@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	7
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	
3.1 Байгууллагын үйл ажилагаа	7
3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин	7
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	8
4. Аудитын тайлан	7
4.1 Ерөнхий зүйл	8
4.2 Дотоод хяналт	9
4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	9
4.4 Материаллаг байдал	9
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	9
5.1 Шилэн дансны мэдээлэл	9
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	10
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал	10
8. Аудитын илрүүлэлт	10
8.1 Залруулсан алдаа	10
8.2 Зөвлөмж	10
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	0

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ААНОАТ	Аж ахуй нэгжийн орлогын албан татвар



1.Аудитын санал дүгнэлт



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Улаанбаатар, Дорнод аймаг, Халхгол сумын Тр-ийн
ЗДТГ-ын 8 байр Улаанбаатар 15114-1215

Ауд. 03.15 № 870

танай _____-ны № _____-т

ДОРНОД АЙМГИЙН ХАЛХГОЛ СУМЫН
ХАЛХГОЛ НЭГДЭЛ ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ
Б.ЗОРИГТХҮҮ ТАНАА



АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дорнод аймгийн Халхгол сумын Халхгол нэгдэл ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дорнод аймгийн Халхгол сумын Халхгол нэгдэл ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.БОЛОРТУУЛ



011020176

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/төгрөгөөр/
			Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>55,345,532.25</u>	<u>21,836,097.53</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	48,327,582.25	11,996,732.04
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	48,327,582.25	11,996,732.04
3121	Төгрөг	48,327,582.25	11,996,732.04
31213	Арилжааны банк дахь харилцах	48,327,582.25	11,996,732.04
33	АВЛАГА	-	2,237,415.49
33402	Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/	-	2,237,415.49
35	БАРАА МАТЕРИАЛ	7,017,950.00	7,601,950.00
354	Хангамжийн материал	7,017,950.00	7,601,950.00
35420	Аж ахуйн материал	7,017,950.00	7,601,950.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>9,586,117,008.83</u>	<u>10,650,677,373.74</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	9,586,117,008.83	10,650,677,373.74
392	Биет хөрөнгө	9,585,127,008.81	10,649,907,373.68
39201	Барилга, байгууламж, орон сууц	8,102,791,115.35	8,256,253,015.35
39202	Хуримтлагдсан элэгдэл	(515,503,979.91)	(761,229,696.78)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	30,858,773.00	30,858,773.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(14,952,924.33)	(19,619,591.01)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	21,456,574.00	45,415,000.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(7,653,713.62)	(8,875,729.64)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	15,252,000.00	14,852,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(9,233,907.39)	(9,456,740.61)
39209	Зам, гүүрийн байгууламж	-	277,571,337.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-	(4,626,188.96)
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,290,945,131.00	3,349,881,738.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(328,832,059.29)	(521,116,542.67)
393	Биет бус хөрөнгө	990,000.02	770,000.06
39301	Програм хангамж	1,100,000.00	1,100,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(109,999.98)	(329,999.94)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>9,641,462,541.08</u>	<u>10,672,513,471.27</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	=	<u>12,317,121.57</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	12,317,121.57
413	Өглөг	-	12,317,121.57
4136	Бусад өглөг	-	12,317,121.57
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	-	12,317,121.57
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>9,641,462,541.08</u>	<u>10,660,196,349.70</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	9,641,462,541.08	10,660,196,349.70
512	Хуримтлагдсан үр дүн	9,641,462,541.08	10,660,196,349.70
51210	Өмнөх үеийн үр дүн	9,641,462,541.08	9,641,462,541.08
51220	Тайлант үеийн үр дүн	-	1,018,733,808.62
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>9,641,462,541.08</u>	<u>10,672,513,471.27</u>

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /төгрөгөөр/
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	9,896,283,700.23	1,974,332,425.92
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,896,283,700.23	1,974,332,425.92
120	Нийтлэг татварын бус орлого	9,896,283,700.23	1,974,332,425.92
120010	Борлуулалтын орлого (цэвэр) /ТӨҮГ/	312,050,321.30	416,237,281.92
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- Үндсэн хөрөнгө	9,582,433,378.93	1,558,095,144.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- Бараа материал	1,800,000.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	262,878,044.77	955,598,617.30
21	УРСГАЛ ЗАРДАЛ	262,878,044.77	955,598,617.30
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	262,878,044.77	955,598,617.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	29,958,510.51	101,138,117.00
210101	Үндсэн цалин	29,958,510.51	-
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/	-	101,138,117.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,108,511.49	29,983,728.45
210201	Тэтгэврийн даатгал	2,210,530.14	-
210202	Тэтгэмжийн даатгал	260,062.37	-
210203	ҮОМШӨ-ний даатгал	208,049.90	-
210204	Ажилгүйдлийн даатгал	39,079.01	-
210205	Эрүүл мэндийн даатгал	390,790.08	-
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	-	29,983,728.45
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	76,328,145.00	70,199,933.76
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	76,328,145.00	70,199,933.76
2104	Хангамж, бараа материалын зардал	119,825,228.00	228,373,969.00
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	101,976,093.00	67,841,828.00
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	17,849,135.00	160,532,141.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,601,731.00	12,328,090.00
210810	Борлуулалт, маркетингийн зардал /ТӨҮГ/	18,477,000.00	-
210811	Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/	85,300.00	-
210812	Санхүүгийн зардал /ТӨҮГ/	120,000.00	-
210813	Бусад зардал /ТӨҮГ/	1,766,546.00	12,328,090.00
210816	Татварын байгууллагад төлсөн	89,135.00	
210817	Даатгалын төлбөрт төлсөн	63,750.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,055,918.77	513,574,779.09
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	13,055,918.77	513,574,779.09
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	9,633,405,655.46	1,018,733,808.62
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	9,633,405,655.46	1,018,733,808.62

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Хуримтлагдсан дүн	/төгрөгөөр/ Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	9,641,462,541.08	9,641,462,541.08
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	9,641,462,541.08	9,641,462,541.08
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	9,641,462,541.08	9,641,462,541.08
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	9,641,462,541.08	9,641,462,541.08
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	9,641,462,541.08	9,641,462,541.08
D08	Тайлант үеийн үр дүн	1,018,733,808.62	1,018,733,808.62
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	10,660,196,349.70	10,660,196,349.70

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	/төгрөгөөр/ Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>312,050,321.30</u>	<u>426,316,988.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	312,050,321.30	426,316,988.00
120	Нийтлэг татварын бус орлого	312,050,321.30	426,316,988.00
120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/	312,050,321.30	426,316,988.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>269,490,976.00</u>	<u>462,647,838.21</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	269,490,976.00	462,647,838.21
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	269,490,976.00	462,647,838.21
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	24,658,013.00	101,138,117.00
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/	24,658,013.00	101,138,117.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,753,666.00	29,983,728.45
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	6,753,666.00	29,983,728.45
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	76,328,145.00	70,199,933.76
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	76,328,145.00	70,199,933.76
2104	Хангамж, бараа материалын зардал	138,351,318.00	248,997,969.00
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	102,066,093.00	190,284,949.00
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	36,285,225.00	58,713,020.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	23,399,834.00	12,328,090.00
210810	Борлуулалт мартетингийн зардал /ТӨҮГ/	18,657,000.00	
210811	Ерөнхий удирдлагын зардал /ТӨҮГ/	1,200,260.00	
210812	Санхүүгийн зардал /ТӨҮГ/	120,000.00	
210813	Бусад зардал /ТӨҮГ/	1,614,346.00	12,328,090.00
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	1,744,478.00	-
210817	Даатгалын төлбөрт төлсөн /ТӨҮГ/	63,750.00	-

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	42,559,345.30	(36,330,850.21)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	42,559,345.30	(36,330,850.21)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	48,327,582.25
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	42,559,345.30	11,996,732.04

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2020 оны гүйцэтгэл	2021 оны			
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Нийт орлого	312,050,321.30	434,735,730.00	426,316,988.00	6,581,258.00	98%
2	Нийт зардал	249,822,126.00	434,735,730.00	442,023,838.21	7,288,108.21	101.6%

3. Санхүүгийн тайлангийн тодруулга

3.1 Байгууллагын үйл ажиллагаа

Халхгол нэгдэл ОНӨААТҮГ-ын зорилго, чиглэлийг сумын нийтийн эзэмшлийн талбайн цэвэрлэгээ, гэрэлтүүлэг, засвар үйлчилгээ явуулна гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд ОНӨААТҮГ гэсэн статустай байна. Өмчийг 100 хувь орон нутгийн өмч эзэмшиж байна.

3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Халхгол нэгдэл ОНӨААТҮГ-ыг иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2014 оны 12 дугаар тогтоолыг үндэслэн байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн "Орон нутгийн өмчийн талаархи иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх" 77.2.4 дэх "орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих" гэсэн заалттай нийцэж байна.

Халхгол нэгдэл ОНӨААТҮГ нь Төлөөлөн удирдах зөвлөл байхгүй.

Монгол Улсын Засгийн газрын "2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 4.4.10-т "Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно." гэж заасан байна. Энэ хүрээнд нутгийн өмчийн бүртгэл судалгааг шинэчлэн тэдгээрийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах зорилгоор сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ажлын албатай хамтран холбогдох байгууллагуудтай байгуулсан ашиглалтын гэрээнүүдэд өөрчлөлт оруулан шинэчлэн баталгаажуулж, гэрээний биелэлтэд хяналт тавин ажиллаж байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" тогтоолын 1.3. "Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;"-д заасны дагуу дотоод зохион байгуулалтын бүтцийг өөрчилж, зардал гаргаагүй байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлтүүд ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Халхгол нэгдэл ОНӨААТҮГ-ын тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

төгрөг/



/мянган

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	48,327.6	11,996.7	-36,330.9
Авлага	-	2,237.4	2,237.4
Бараа материал	7,017.9	7,601.9	584.0
Үндсэн хөрөнгө	9,586,117.0	10,650,677.4	1,064,560.4
Нийт хөрөнгийн дүн	9,641,462.5	10,672,513.4	1,031,050.9
Өр төлбөрийн дүн	-	12,317.1	12,317.1
Эздийн өмч	9,641,462.5	10,660,196.3	1,018,733.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	9,641,462.5	10,672,513.4	1,031,050.9

Банк дахь харилцах дансанд 12.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Тайлант оны 8-р сард НӨАТ суутган төлөгчөөр бүртгүүлснээр 2.2 сая төгрөгийн НӨАТ-ын буцаан авалттай байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 7.6 сая төгрөг болж 0.6 сая төгрөгөөр өссөн нь худалдан авалтаас шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь 20.0 сая төгрөгийн хөрөнгө худалдан авч, үнэ төлбөргүй 1,558.1 сая төгрөгийн хөрөнгө хүлээн авч, 64.6 сая төгрөгийн хөрөнгө акталсантай холбоотой байна.

Богино хугацаат өр төлбөр данс 12.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Энэ нь тайлант онд татварын хяналт шалгалтаар НӨАТ суутган төлөгчөөр хуулийн хугацаанд бүртгүүлээгүй зөрчлөөр 2.5 сая төгрөгийн торгууль, 1.0 сая төгрөгийн алданги, 8.6 сая төгрөгийн нөхөн татвар ногдуулсныг төлөөгөйтэй холбоотой байна. Мөн жилийн эцсээр аж ахуй нэгжийн орлогын албан татварын 0.2 сая төгрөгийн өртэй гарсан байна.

3.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Халхгол нэгдэл ОНӨААТҮГ байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Халхгол нэгдэл ОНӨААТҮГ нь 2021 оны үйл ажиллагаа болон орлогын төлөвлөгөөг сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар батлуулсан байна.

4. Аудитын тайлан

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Халхгол нэгдэл ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад НӨАТ суутган төлөгчийн бүртгэлтэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Нармандах, аудитор Б.Оюунхэрлэн нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер И.Сэмжидмаа, дарга, тэргүүлэх аудитор Б.Болортуул нар хэрэгжүүлсэн.

Халхгол сумын Халхгол нэгдэл ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланг Дорнод аймаг дахь төрийн аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Дотоод хяналт

Халхгол нэгдэл ОНӨААТҮГ нь дотоод хяналтын нэгжгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Санхүүгийн хяналт аудитын албанаас 2021 онд хяналт шалгалт хийгдээгүй бөгөөд татварын хэлтсээс эрсдэлд суурилсан хяналт шалгалт хийсэн байна.

4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Халхгол нэгдэл ОНӨААТҮГ нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

4.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 262.8 сая төгрөгөөс 1 хувиар буюу 2.6 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Халхгол нэгдэл ОНӨААТҮГ нь тайлант онд Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хуулийн дагуу мэдээллийг бүрэн байршуулсан байна.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудит хийгдээгүй.

Өмнөх онд түүвэрт хамрагдсан байна.

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх, анхаарал татахуйц асуудал гараагүй.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 18.5 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 18.5 сая төгрөгийн алдааг залруулж, зөвлөмж өгсөн.

8.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 18.5 сая төгрөгийн 3 алдааг залрууллаа. Үүнд:

- Илүү төлсөн цахилгааны төлбөрийг ДБЭХС ТӨХК-аас буцаан шилжүүлсэн 4.0 сая төгрөгийг орлогоор бүртгэснийг залруулсан.
- Тайлант оны 8-р сард татварын хяналт шалгалтаар 3.5 сая төгрөгийн торгууль алданги, 8.6 сая төгрөгийн нөхөн татвар ногдуулсныг төлөөгүй бөгөөд өглөгөөр бүртгээгүй байна. Жилийн эцсийн 0.2 сая төгрөгийн ААНОАТ-ын өглөгийг бүртгээгүй байсныг залруулсан.
- Санхүүгийн программ дээр борлуулалт болон худалдан авалтын НӨАТ-ыг тусад нь салгаж бүртгэдэггүйгээс НӨАТ-ын авлага, өглөг үүсээгүй байна. Үүнээс үүдэн НӨАТ-ын 12-р сарын тайлангаар 2.2 сая төгрөгийн НӨАТ-ын буцаан авалттай гарсан нь тайланд тусгагдаагүй байсныг залруулсан.

8.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. НӨАТ суутган төлөгчөөр бүртгүүлсэнтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант оны 8-р сараас НӨАТ суутган төлөгчөөр бүртгүүлсэн ч санхүүгийн программ дээр НӨАТ-тай борлуулалт болон худалдан авалтын НӨАТ-ыг тусад нь салгаж бүртгээгүй байна. Үүнээс үүдэн НӨАТ-ын авлага, өглөг үүсэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Санхүүгийн программ дээр борлуулалтад ногдох НӨАТ, худалдан авалтад ногдох НӨАТ-ыг НӨАТ-ын авлага, өглөгөөр тусад нь салгаж бүртгэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Залруулга		Акт		Үүнээс		Зөвлөмж		
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар															
1	Халхгол нэгдэл ОНЭААТҮГ	ДОА-2022/09/НА/СТА-ОНА	Н5Б тухай хуулийн хэрэгжилтэй холбоотой.	Хуулийн хэрэгжүүлж ажиллах	4	18,565.7	3	18,565.7							
ДҮН					4	18,565.7	3	18,565.7							

/Мянган төгрөгөөр/

1117144045
ХТҮ/0037 9933991